



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4 сарын 29 өдөр

№ 24/01

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай


Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.8 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 24/06 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА,



Ч.ХАШЧУЛУУН





МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4 сарын 29 өдөр

№ 49/02

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.15 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.13 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 24/07 дугаартай тогтоолын 2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлын 22/02 дугаартай “Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг хүчингүй болгосугай.





МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4 сарын 29 өдөр

№ 44/03

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2-т *"Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол /14210/, Энхтайваны өргөн чөлөө 19, 13-р давхар"* гэснийг *"Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу /15160/, Д.Сүхбаатарын талбай гудамж, 11 тоот"* гэж өөрчилсүгэй.
2. Энэ тогтоолын 1-т заасан нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийн талаар хувьцаа эзэмшигч, олон нийтэд мэдээлэх болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА,

МИК
ХОЛДИНГ

УЛААНБААТАР ХОТ
Ч.ХАШЧУЛУУН





МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

20 24 оны 4 сарын 29 өдөр

№ 24/04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.7 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2024 оны 3 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Дараах нэр дэвшигчдийг “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар сонгосугай. Үүнд:
 - Атарбаатарын Энхжин, Монголбанкны төлөөлөл ;
 - Бат-Өлзийн Сайнзаяа, Монгол улсын хөгжлийн банкны төлөөлөл;
 - Товуудоржийн Даваажав, Худалдаа хөгжлийн банкны төлөөлөл;
 - Мягмарын Мөнхбаатар, “Азиа дайверсифайд рийл эстэйт фонд нэг” ХХК-ийн төлөөлөл;
 - Нямдоржийн Сэргэлэн, “Ти Ди Би секьюритис ҮЦК” ХХК-ийн төлөөлөл;
 - Батцэнгэлийн Үүрцайхбаатар, “Капитрон банк” ХК-ийн төлөөлөл.
- Дараах нэр дэвшигчдийг “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар сонгосугай. Үүнд:
 - Чулуундоржийн Хашчулуун, МУИС-ийн Дэд профессор;
 - Амаржаргалын.Анар, “Синержи Фонд Солюшн ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал;
 - Энхбаярын Шижир. Уул уурхай металлургын цогцолбор байгуулах төслийн удирдагч.
- Энэ тогтоолын 1, 2-г зааснаар шийдвэрлэснийг Санхүүгийн зохицуулах хороонд болон арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан хувьцаа эзэмшигч, олон нийтэд тус тус мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.
- Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.





МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

20 ²⁴ онны ⁴ сарын ²⁹ өдөр

№ ^{24/05}

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах гухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.12 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2024 оны 4 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2024 оны 5 дугаар 01-ний өдрөөс 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх цалингийн зардлын төсвийг энэ тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын Хавсралтаар батлагдсан зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороонд даалгасугай.





"МИК Холдинг" ХК-ийн

Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал

24/05 дугаартай тогтоолын Хавсралт

**"МИК ХОЛДИНГ" ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН
ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

/2024.05.01-Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурал/

Зардлын төрөл	Сарын налин		Давтамж	Хүний тоо	Нийт			Үүнээс:			
	суурь	нэмэгдэл			суурь	нэмэгдэл	нийт	2024/05/01-2024/12/31		2025/01/01-2025/04/30	
								суурь	нэмэгдэл	суурь	нэмэгдэл
Цалин	700,000	500,000	12	9	75,600,000	54,000,000	129,600,000	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
ТУЗ-ийн гишүүн	700,000	500,000	12	9	75,600,000	54,000,000	129,600,000	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
НДШ	86,100	61,500	12	9	9,298,800	6,642,000	15,940,800	6,199,200	4,428,000	3,099,600	2,214,000
Нийт зардал	786,100	561,500	12	9	84,898,800	60,642,000	145,540,800	56,599,200	40,428,000	28,299,600	20,214,000